



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/102

Цагаан-Уул сум

Баруун бүсийн хурдан морьдын  
Уралдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хөвсгөл аймгийн баруун бүсийн дээд 3 насны хурдан морьдын уралдааныг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Баяр наадмын бэлтгэл ажлын төлөвлөгөөг гаргаж танилцуулан ажиллахыг зохион байгуулах комиссын дарга (А.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.
3. Баруун бүсийн дээд 3 насны морьдын уралдааныг ардын өв уламжлалаа хадгалж, сахилга бат, нийгмийн дэг журмыг сахин, ёслол хүндэтгэлийн өндөр хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэхийг уриалсугай.
4. Энэхүү Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-д даалгасугай.

ДАРГА

С.ТОНЧИГНЯМ

